

*Сурган хүмүүжүүлэх ухааны нэрт эрдэмтэн, доктор, дэд профессор Г. Эрдэнэ-Очирын мэндэлсний 60 жилийн ойд зориулсан хүндэтгэл, дурсамжийн хуралд зориулав.*

## Доктор Г.Эрдэнэ-Очирын амьдрал, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа

Д.Төмөр



1949 оны 03 сарын 01-нд Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Морьт бригадын нутаг Цагаан худаг хэмээх газар малчин ард Гэндэн-Яринпилийн долоо дахь хүү болон төржээ. 9 нас хүртэл эцэг эхийн гар дээр өсөн хүмүүжиж, 1958 онд Дундговь аймгийн Говь-Угтаал сумын бага сургуульд элсэн орж 1959 онд тэр үеийн Монголын Пионерийн байгууллагад элсэн орсон.

Бага сургуулиа төгсөж Дундговь аймгийн төвийн арван жилийн сургуульд элсэн орж, суралцах хугацаанд сурлага сахилга батаараа тэргүүний сурагч байсан төдийгүй сонгуульт ажлыг сайн гүйцэтгэдэг Үбүлгэмийн зөвлөлийн дарга, нийгмийн идэвх сайтай хүүхэд байж, 1965 онд сурлага сахилга батаараа шалгаран тэр үеийн БНУАУ-ын олон улсын пионерийн зусланд амарч байжээ.

Г.Эрдэнэ-Очир 1968 - 1972 онд УБДС-ийн монгол хэл-уран зохиолын ангид суралцан, багш мэргэжлээр уул сургуулиа дүүргэн, нутагтаа хуваарилагдан, **ажил хөдөлмөрийн** гараагаа 1972 оны 7 сараас Дундговь аймгийн Говь-Угтаал сумын дунд сургуулиас эхэлсэн.

- 1972 – 1979 онуудад Дундговь аймгийн Говь-Угтаал сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч, захирал, аймгийн Сургалт-заах аргын кабинетийн эрхлэгчээр



- 1979 – 1990 онуудад АБЯ-ны СХУ-ны онол арга зүйн төв хэвлэл “Сурган хүмүүжүүлэгч” болон “Хүүхдийн хүмүүжил” сэтгүүлийн утга зохиолын ажилтан, хариуцлагатай нарийн бичгийн дарга, сэтгүүлийн нэгдсэн редакцийн эрхлэгч, МАХН-ын Төв Хорооны намын байгууллагын хэлтэст зааварлагч, нарийн бичгийн дарга, туслахаар

- 1990 – 1997 онуудад АБЯ-ны Сурах бичиг, хүүхдийн номын хэвлэлийн газрын захирал, Багшийн Коллеж-д багш, УБИС-ийн уран зохиолын тэнхимд багш, эрдэмтэн нарийн бичгийн даргаар тус тус ажиллаж байлаа.





Энэ хугацаанд Дундговь аймгийн Говь-Угтаал сумын ардын хурлын депутат, Дундговь аймгийн ХЗЭ-ны хороонд Бүгд хурлын гишүүн, Мандалговь хотын ардын хурлын депутат, Нийслэлийн Сүхбаатарын районы намын коммунист гишүүн, АБЯ-н Сурах бичиг, хүүхдийн ном, хэвлэлийн газрын намын үүрийн нарийн бичгийн дарга, Нийгмийн ухааны акадemiийн намын үүрийн товчооны гишүүн зэрэг сонгуульт ажлыг гүйцэтгэж явсан.

Мэргэжил боловсролоо дээшлүүлэхийн тулд 1974 – 1991 онуудад ЗХУ, Беларус, Япон зэрэг улсуудад, мөн МАХН-н ТХ-н дэргэдэх намын дээд сургуулийн удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх курст, ЗХУ-ын Москва хотноо Нийгмийн ухааны акадemiид тус тус суралцаж төгссөн байна.



“Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүй” сэдвийг олон хүн судлаагүй байхад энэ сэдвийг сонгон авч судлан, 1971 онд Ардын хувьсгалын 50жилийн ой угтан Дээд сургуулиудын дунд зарласан Оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаанд 3-р байр эзэлж, 1972 онд УБДС-ийн монгол хэл - уран зохиолын ангийг төгсөхдөө “Монгол ардын зүйр цэцэн үгийн тухай” сэдвээр дипломын ажлаа хамгаалсан. Энэ л үеэс эрдэм шинжилгээ судалгааны ажил нь эхэлсэн.

1993онд “Монгол ардын сурган хүмүүжүүлэх уламжлал, түүний хөгжил” сэдвээр сурган хүмүүжүүлэх ухааны докторын зэрэг хамгаалж, 1996 онд сурган хүмүүжүүлэх ухааны дэд профессор болсон.

Г.Эрдэнэ-Очир нь сэтгүүлч, сурган хүмүүжүүлэгч, багш болохынхоо хувьд олон



арван сурвалжилга, тэмдэглэл, нийтлэлийг төвийн болон орон нутгийн сонин хэвлэлд нийтлүүлэн, Монгол ухааны өв уламжлалыг дээдлэн дээшилж уг шагийг нь мушгин шинжилж, олон ном сэлт туурвин бүтээсэн юм.

Ийнхүү бие даасан зохиол бүтээл 10, орчуулж нийтлүүлсэн материал 17, Төвийн сонин хэвлэлд нийтлүүлсэн материал 67, тэр дундаа ардын сурган хүмүүжүүлэх зүйн сэдвээр 5 ном, 20 гаруй өгүүлэл бичсэн байна.

Г.Эрдэнэ-Очирын мааньажилхөдөлмөрийг нь төр засгаас үнэлэн Монгол Улсын АБЯ-ны “Боловсролын тэргүүний ажилтан”, “Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан” цолоор, Монголын Залуучуудын Холбооны “Тэргүүний сэхээтэн залуу” алтан медаль, АБЯ-ны “Тэргүүний багш”, Монголын Залуучуудын Холбооны “Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч” цол, Ардын хувьсгалын 60, 70 жилийн ойн медалиудаар тус тус шагнасан.

Эдүгээгэргий Д.Даваасүрэн, хүү Э.Идэрболд, Э.Идэрцог, охин Э.Ижилцэцэг, Э.Наранцэцэг, ач хүү И.Анхбаяр, И.Энхбаяр, зээ охин Э.Эгшиглэн нар нь багш, орчуулагч - менежер, цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгийн дарга, сэтгүүлч, утга зохиолын ажилтан зэрэг ажлыг хийж, ач зээ нар нь ерөнхий боловсролын сургуулиудад суралцаж байна.

